



59

Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04-р сарын  
20-ны өдрийн 02 тоот тогтоолын Хавсралт

**“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ДҮРЭМ**  
(Шинэчилсэн найруулга)

Монгол улс  
Улаанбаатар хот

2015

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ



1.1. “Дархан гурил тэжээл” ХК(цаашид “компани” гэх)–ийн дүрмээр компанийн эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, удирдлага, зохион байгуулалт, хувь нийлүүлсэн хөрөнгө, компанийн хувьцаа, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Компани нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон энэхүү дүрмийн хүрээнд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах нээлттэй хувьцаат компани (ХК) байна.

1.3. Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулан ажиллуулж болно.

1.4. Компанийн оноосон нэрийг монгол хэлээр “Дархан гурил тэжээл” ХК, англи хэлээр “Darkhan flour milling” Co.,Sh. гэнэ.

1.5. Компанийн хаяг:

“Дархан гурил тэжээл” ХК  
Дархан-Уул аймаг, Дархан сум, 1-р баг  
Өөрийн байр.  
Утас: 33046, Факс: 976-11-372-33046

Электрон шуудангийн хаяг: [sosnamsrai@yahoo.com](mailto:sosnamsrai@yahoo.com)

1.6. Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь компанийн оноосон нэрийг хэрэглэх ба тус бүрийн хаягтай байна.

1.7. Компани нь өөрийн билэгдэл, тэмдэг, барааны тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Тэмдэг нь компанийн оноосон нэрийг монгол хэлээр бүтнээр нь тусгаж, билэгдэл, регистрийн дугаарыг агуулна. Тэмдгийг албан ёсны баримт бичиг, шийдвэрийн үнэн зөв бөгөөд жинхэнэ болохыг гэрчлэхийн тулд хэрэглэнэ.

## ХОЁР. КОМПАНИЙН ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Компани нь дор дурдсан үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ. Хуулиар хориглоогүй бол бусад үйл ажиллагааг эрхэлж болно. Үүнд:

- 2.1.1. гурилын үйлдвэрлэл, худалдаа;
- 2.1.2. малын тэжээлийн үйлдвэрлэл, худалдаа;
- 2.1.3. гадаад, дотоод худалдаа;
- 2.1.4. улаан буудай хадгалах.
- 2.1.5. үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж угсрах, засварлах
- 2.1.6. газар тариалан эрхлэх

2.2. Компани нь татан буугдсан, дампуурсан болон эрх зүйн бусад шалтгааны улмаас үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэн явуулах үндэслэлгүй болсноос бусад тохиолдолд үйл ажиллагаагаа тодорхой бус хугацаагаар явуулна.



## ГУРАВ. КОМПАНИЙН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА

3.1. Компанийн балансад тусгагдсан тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ.

3.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийннийт хэмжээ нь компанийн зарласан хувьцааны хэмжээнд багтаан гаргасан хувьцааны орлоготой тэнцүү байна

3.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно:

3.3.1. нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бууруулах;

3.3.2. хувьцаа нэмж гаргах замаар өсгөх;

3.3.3. өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах.

3.4. Компанийн хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг хувьцаа эзэмшигчийн эрхийг гэрчилнэ.

3.5. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь энгийн болон давуу эрхийн хувьцааг гаргах ба энгийн хувьцааг заавал гаргана.

3.6. Хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байх бөгөөд тухайн компанийн нэг төрлийн хувьцааны нэрлэсэн үнэ ижил байна. Хувьцааг нэрлэсэн үнээс нь доогуур үнээр гаргахыг хориглоно.

3.7. Компани нь нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 614603 (зургаан зуун арван дөрвөн мянга зургаан зуун гурван) ширхэг зарласан болон гаргасан хувьцаатай байна.

3.8. Хувьцаа эзэмшигчид болон эзэмшиж буй хувьцааны байдлыг хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд тусгасан байна. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн компани хөтөлнө.

3.9. Энгийн хувьцаа нь хуваагдахгүй бөгөөд хувьцаа тус бүр нь 1 (нэг) саналын эрхтэй байна.

## ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

4.1. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх, үүрэгтэй:

4.1.1. хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;

4.1.2. давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;

- 4.1.3. компанийг татан буулгах үед энэ Компанийн тухай хуульд заасан журмын давуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх.
- 4.1.4. компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэгүүн эзэлжид худалдан авах;
- 4.1.5. компанийн хяналтын болон удирдах байгууллагыг сонгох, түүний бүрэлдэхүүнд сонгогдох;
- 4.1.6. компанийн үйл ажиллагааны тухай мэдээлэл, тайлан, тооцоо болон бусад баримт бичиг, удирдах байгууллагын хурлын тэмдэглэлтэй танилцах;
- 4.1.7. холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу өөрийн эзэмшиж буй хувьцааг худалдаж авахыг компаниас шаардах;
- 4.1.8. энэ дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжид заасан бусад эрх.

4.2. Компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан эрхтэй байна.

4.3. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

- 4.3.1. Монгол Улсын хууль тогтоомж, хувьцаа гаргах тухай шийдвэрт заасан журам, хугацаа, аргаар худалдан авч байгаа хувьцааныхаа үнийг төлөх;
- 4.3.2. энэ дүрэм, компанийн удирдах байгууллагын эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шаардлагыг биелүүлэх;
- 4.3.3. өөрийн оршин байгаа хаягийн өөрчлөлтийг тухай бүрд нь компанид мэдэгдэж байх;
- 4.3.4. энэ дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

4.4. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

4.5. Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч болон компанийн үйл ажиллагааг бусад хэлбэрээр тодорхойлох эрх бүхий этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

### **ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

- 5.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 5.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг товлон зарласан газар хуралдуулна.
- 5.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэсэн бүх асуудлаар тогтоол гаргана. Тогтоолд хурлын дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө. Хэлэлцсэн асуудал, тэмдэглэл, тогтоолыг компанийн бүртгэлд бүртгэж хадгална.
- 5.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:
- 5.4.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;



5.4.2. ийгүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

5.4.3. компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

5.4.4. компанийн хэлбэрийг өөрчлөх;

5.4.5. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

5.4.6. хувьцааг хуваах буюу нэгтгэх;

5.4.7. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

5.4.8. компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;

5.4.9. жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

5.4.10. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

5.4.11. компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;

5.4.12. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, тогтоох;

5.4.13. төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

5.4.14. компанийн тухай хуулиар зохицуулсан бусад асуудал.

5.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хуралд оролцож буй хувь нийлүүлэгчдийн 50 (тавь)-аас дээш хувийн саналаар хэлэлцэж болно.

5.6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.

5.7. Дараах тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:

5.7.1. төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;

5.7.2. төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;

5.7.3. компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;

5.7.4. компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;

5.7.5. төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан;

5.7.6. аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан.

5.8. Энэ дүрмийн 5.7.2-т заасан этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай санал, шаардлагыг төлөөлөн удирдах зөвлөлд гаргана.

5.9. Энэ дүрмийн 5.7.2-т заасан санал, шаардлагыг бичгээр гаргах бөгөөд түүнд санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ээлжит бус хурал хуралдуулах болсон шалтгаан, хэлэлцэн шийдвэрлэх асуудал, хурлаас гаргах шийдвэрийн төсөл, өөрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоог заана.





5.19. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Хувьцаа эзэмшигчдийн хурлаас өмнө итгэмжлэлийг санал хураалт эхлэхээс өмнө тооллогын комисст өгсөн байх бөгөөд түүнийг тухайн хурлын холбогдох баримт бичгүүдийн хамт хадгална.

5.20. Төлөөлөх итгэмжлэл нь зөвхөн тухайн хуралд хүчинтэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй байна.

5.21. Ирц бүрдэлт: Саналын эрхтэй нийт хувьцааны 50 (тавь)-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид буюу тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

5.22. Энэ дүрмийн 5.21-д заасан ирц бүрдээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг товлоно. Хойшлогдсон хурал хуралдуулах асуудлыг дараах журмаар зохицуулна. Үүнд:

5.22.1. хойшлогдсон хурлыг ажлын 20 (хорь) хоногийн дотор хуралдуулах бөгөөд хурал болох газар, өдөр, цагийг хурал хуралдахаас ажлын 7 (долоо)-оос доошгүй хоногийн өмнө дахин мэдээлнэ. Харин хойшлогдсон хурлаар хэлэлцэхээр товлосон асуудлыг өөрчилж үл болно;

5.22.2. саналын эрхийн 50 (тавь) ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно;

5.22.3. түрүүчийн хуралд бичгээр ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын тухайн хэлэлцэх асуудлын санал хураалтын дүнд оруулан тооцно;

5.22.4. хойшлогдсон хурал нь ажлын 20 (хорь) хоногийн дотор хуралдаж чадахгүй бол шинээр хурал зарлах бөгөөд ийнхүү шинээр зарласан хурлын ирц /кворум/-ийг энэ дүрмийн 5.18-т зааснаар тооцно.

5.23. Хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж буй асуудлыг хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

5.24. Тооллогын комисс: Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргасан этгээд хурлын тооллогын комиссыг томилох бөгөөд уг комиссын үүргийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр тогтоож болно.

5.25. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс дараах үүрэг хүлээнэ:

5.25.1. хурлын ирц /кворум/-ыг тогтоож, хурлын даргад мэдээлэх;

5.25.2. тухайн хурлын хэлэлцэх асуудал тус бүрээр оролцогч бүрийн саналын эрхийн тоо, төрлийг тогтоох;

5.25.3. хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах асуудалд тайлбар өгөх;

5.25.4. санал өгөх журмыг тайлбарлах;

5.25.5. санал өгөх журам болон хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;

5.25.6. санал хураалтыг саналын хуудсаар явуулж байгаа тохиолдолд уг саналын хуудсыг тоолж, хүлээн авах;

5.25.7. санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх;

5.25.8. санал тоолж, санал хураалтын дүнг нэгтгэж, дүнгийн тухай шийдвэр гаргах тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хуралд танилцуулах;

5.25.9. саналын хуудсыг компанийн архивт хадгалуулахаар шилжүүлэх.

5.26. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнгийн үнэн зөвийг хариуцна.

### ЗУРГАА. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь есөн гишүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) байна.

6.2. Компанийн зохистой засаглалын зарчмыг хангахын тулд ТУЗ-ийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

6.3. ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг улс төр, эдийн засаг, бусад зохисгүй ашиг сонирхлын нөлөөнд үл автан бие даан шийдвэр гаргах чадвар бүхий гишүүдээс бүрдүүлэх ба гишүүдийн тоо, мэргэжлийн ур чадвар болон хувийн зан чанар нь компанийн үйл ажиллагааны стратегийн ач холбогдол бүхий асуудлыг хараат бус байдлаар шийдвэрлэх бололцоог бүрдүүлсэн байна.

6.4. ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.4.1. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;

6.4.2. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

6.4.3. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

6.4.4. компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;

6.4.5. компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;

6.4.6. эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

6.4.7. өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;

6.4.8. компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

6.4.9. компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;

6.4.10. аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;

6.4.11. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

6.4.12. ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;

6.4.13. компанийн дотоод бүтэц, зохион байгуулалт, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон хороодын ажиллах дотоод журмыг батлах;

6.4.14. компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;

6.4.15. компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

6.4.16. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

6.4.17. энэ дүрэм болон хууль тогтоомжор тогтоосон бусад асуудал.





6.5. Энэ дүрмийн 6.4.6, 6.4.10, 6.4.16-т д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд заавал оролцож саналаа өгнө.

6.6. ТУЗ нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.6.1. компанийн үйл ажиллагааны стратеги бодлогыг тодорхойлж, уг бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тодорхой болгосон байх;

6.6.2. санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлдэг байх;

6.6.3. гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих замаар гүйцэтгэх удирдлагын үр дүнтэй үйл ажиллагааг хангадаг байх;

6.6.4. хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хагаалдаг байх;

6.6.5. үйл ажиллагааны тодорхой чиглэлээр ТУЗ-д зөвлөгөө үзүүлэх, түүний чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлж өгөх.

6.7. ТУЗ-ийн дарга, гишүүн нь дараахь үүргийг хүлээнэ:

6.7.1. хууль тогтоомж болон дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил, үүргээ хариуцлагатай биелүүлэх;

6.7.2. компанийн эрх ашгийг хувийн болон өөрийг нь сонгосон этгээдийн эрх ашгаас дээгүүр тавих;

6.7.3. сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчилүүссэнүед ТУЗ-дмэдээлдэгбайх.

6.8. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дараахшалгуурыгхангасанбайна:

6.8.1. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;

6.8.2. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй;

6.8.3. төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;

6.8.4. компанитай бизнесийн аливаа холбоогүй.

6.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь бусад гишүүний адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ:

6.9.1. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлбэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;

6.9.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

6.9.3. хувьцаа эзэмшигчдийн хуралд биеллэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.

6.10. ТУЗ нь дэргэдээ аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байна.



6.11. ТУЗ-ийн дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа сонгогдсоноос хойш (гурван) жил байна. Дарга, гишүүдийг хэдэн ч удаа улируулан сонгож болно.

6.12. ТУЗ-ийн аль нэг гишүүн, дарга нь хугацаанаас өмнө зөвлөдөөс гарсан бол шинээр сонгогдсон гишүүн нь тухайн удаагийн ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа дусгал ажиллана.

6.13. ТУЗ-ийг гишүүд дотроосоо сонгосон дарга удирдана.

6.14. ТУЗ-ийн үйл ажиллагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна. ТУЗ-ийн ээлжит хурал: ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд 1 (нэг)-ээс доошгүй удаа хийж, шаардлагатай бол ээлжит бус хурал хийж болно. Ээлжит хурлыг ТУЗ-ийн товлосон газар хийнэ. ТУЗ-ийн гишүүдэд хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох материалыг ажлын 2 (хоёр)-оос доошгүй хоногийн өмнө баталгаат шуудан, факс, электрон шуудангаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хүргүүлнэ.

6.15. ТУЗ-ийн ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүд болон Гүйцэтгэх удирдлага зарлан хуралдуулж болно. ТУЗ нь шийдвэрийг хурлаас гадуур санал хураах замаар гаргаж болно.

6.16. Ирц бүрдэлт: ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор ТУЗ-ийн хурал хүчин төгөлдөр болж, оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

6.17. Хэрэв ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцвэл ТУЗ-ийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

6.18. ТУЗ-ийн шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарна.

6.19. Цалин: ТУЗ-ийн гишүүдэд хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан хэмжээгээр цалин, урамшуулал олгоно. ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хуралд биечлэн оролцохтой холбогдон гарсан бодит зардлаа компаниар төлүүлж болно.

6.20. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.

6.21. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга дараах үүрэг хүлээнэ:

6.21.1. хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчид мэдээлэл хүргэх;

6.21.2. хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах;

6.21.3. хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих;



6.21. Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулах;

6.21.5. төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулах.

6.22. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:

6.22.1. хурал хуралдсан газар, өдөр, цаг;

6.22.2. хуралд оролцсон гишүүд;

6.22.3. хурлаар хэлэлцсэн асуудал;

6.22.4. санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн;

6.22.5. гаргасан шийдвэр.

6.23. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг тухайн хурлын дарга хариуцна.

#### ДОЛОО. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

7.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх захирал нь хэдэн ч удаа улиран томилогдож болно.

7.2. Гүйцэтгэх захирлын эрх хэмжээ, цалин урамшуулал, холбогдох асуудлыг ТУЗ-тай байгуулсан контрактаар нарийвчлан зохицуулна.

7.3. Гүйцэтгэх захирлын эрх хэмжээнд Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамааруулснаас бусад компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлууд хамаарна. Гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомж, компанийн дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн шийдвэрийн биелэлтийг хариуцан ажиллана. Гүйцэтгэх захирал нь хууль тогтоомж, энэ дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, ТУЗ-ийн өмнө ажлаа тайлагнана.

7.4. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэр байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

7.5. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно. Харин ТУЗ-ийн дарга байхыг хориглоно.

7.6. Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга болон гишүүнд гаргаж болно.

7.7. Гүйцэтгэх захирал томилогдсоноосоо хойш 7 (долоо) хоногийн дотор гарын үсгийнхээ загварыг харилцагч банкны байгууллагуудад тэмдэглүүлнэ.

7.8. Гүйцэтгэх захирал нь дор дурьдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ:

7.8.1. энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, ТУЗ-ийн шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;



- 7.8.2. хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх, компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
  - 7.8.3. үүрэг гүйцэтгэх явцад олж авсан компанийн талаархи мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх, нууцыг чандлан хадгалах;
  - 7.8.4. энэ дүрэм болон холбогдох хууль тогтоомжид заасан асуудлаар дүрэм заавар, журмыг боловсруулж, ТУЗ-д батлуулахаар өргөн барих;
  - 7.8.5. ажиллагсдын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;
  - 7.8.6. хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар заавар, журам батлах, тэдгээрийг баримтлан ажиллах;
  - 7.8.7. компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;
  - 7.8.8. ТУЗ-өөс баталсан зөвлөмж, дүрэм, журам, стратегийн төлөвлөгөөний биелэлтийг хангах;
  - 7.8.9. ТУЗ-өөс тогтоосон бүтэц, зохион байгуулалт, орон тоо, ажил, албан тушаалын жагсаалт, цалингийн сан зэрэгт нийцүүлэн газар, нэгж байгуулах, татан буулгах, тэдгээрийн удирдлага, ажилтнуудыг томилох, ажлаас чөлөөлөх;
  - 7.8.10. компанитай хийх хэлэлцээрт оролцож байгаа этгээд нь Компанийн тухай хуульд заасан нэгдмэл сонирхолтой этгээд байгаа бол энэ тухайгаа нэн даруй ТУЗ-д бичгээр мэдэгдэх;
  - 7.8.11. компанийн баланс, үйл ажиллагааны үндсэн чиглэл, бизнес төлөвлөгөө, ашиг хуваарилах болон бусад шаардлагатай асуудлаар боловсруулалт хийж ТУЗ-ийн хуралд хэлэлцүүлэхээр оруулах;
  - 7.8.12. компанид чруулсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, компанид холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;
  - 7.8.13. хувийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх;
  - 7.8.14. компанийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;
  - 7.8.15. ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн эд хөрөнгө, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах, үндсэн хөрөнгийг олж авах, худалдах;
  - 7.8.16. компанийн жилийн эцсийн ажлын үзүүлэлтийг ханган биелүүлсний шагнал, урамшуулал хүртэх;
  - 7.8.17. контрактад заасан бусад эрх, үүрэг.
- 7.9. Гүйцэтгэх захирал ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, удаан хугацаагаар өвчлөх тохиолдолд өөрийн эрх, үүргийг бүхэлд нь Гүйцэтгэх захирлын шийдвэрээр томилсон этгээдэд шилжүүлнэ. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 7.10. Гүйцэтгэх захирлыг хууль тогтоомж, энэхүү дүрэм болон Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактад заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө албан тушаалаас нь чөлөөлж болно.

**НАЙМ. КОМПАНИЙН САНХҮҮ БҮРТГЭЛ, ТАЙЛАН**



8.1. Компани нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хэвлүүлнэ.

8.2. Санхүүгийн тайлан нь тайлан тэнцэл, орлого, үр дүнгийн тайлан, хуримтлагдсан ашгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нэмэлт тайлбар, тодруулгаас бүрдэнэ.

8.3. Санхүүгийн тайлангуудын үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч хариуцаж гарын үсэг зурах бөгөөд компанийн тэмдгээр баталгаажуулна.

8.4. Компанийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг сонгон ажиллуулж болно.

8.5. Аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг ТУЗ батална. Гэрээнд компанийн болон аудиторын эрх, хүлээх үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.

8.6. Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн хуралд зөвхөн тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.

8.7. Нэгдмэл сонирхолтой этгээд, бкомпанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтныг аудитороор сонгон ажиллуулахыг хориглоно.

### **ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮРТГЭЛ**

9.1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх, түүнчлэн ногдол ашиг авах, санал хүсэлт гаргах зэрэг эрхийг эдлүүлэхэд баримтлах гол баримт нь компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэл болно.

9.2. Энгийн болон давуу эрхийн хувьцаа, тэдгээрт хөрвөх үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтөлнө.

9.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн нарийн бичгийн даргад хадгалагдаж буй компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлтэй танилцах эрхтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг хувьцаа эзэмшигч өөрөө хариуцна.

9.4. Компани нь ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, уг хурлаас гарсан шийдвэр, тогтоол зэрэг баримт бичигтэй танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгоно. Худалдааны нууц, үйлчлүүлэгчийн нууц болон бусад бизнесийн мэдээлэл агуулсан баримт бичгийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах үүргийг компани хүлээхгүй.

9.5. Үнэт цаас гаргах, их хэмжээний хэлцэл байгуулах зэрэг хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нөлөөлөхүйц шийдвэрийн талаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах журмын дагуу мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэн тохиолдолд түүнд эрхээ хэрэгжүүлэх боломж олгосон гэж үзнэ.

### **АРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ**



10.1. Ногдол ашиг: ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа тус бүрт хуваарилан олгох ногдол ашгийн хэмжээг тогтооно. Ногдол ашиг хуваарилан олгох, эсэх асуудлыг ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахаас өмнө хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг хуваарилан олгох ажлыг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.

10.2. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигч нь хуваарилагдсан ногдол ашгаа авах эрх үүснэ.

10.3. Дор дурьдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:

10.3.1. ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;

10.3.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;

10.3.3. компани нь эргүүлэн худалдаж авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

10.4. Компани эргүүлэн худалдаж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

10.5. Компани нь дараах нөхцөлд давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:

10.5.1. ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;

10.5.2. компани нь эргүүлэн худалдаж авах үүрэгтэй давуу эрхийн хувьцааг бүрэн авсан байх.

**АРВАН НЭГ. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ,  
ТАТАН БУУЛГАХ**

11.1. Компанийг энэ хуульд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

11.2. Компанийг өөрчлөн байгуулах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор өөрчлөн байгуулагдсан компани нь зээлдүүлэгч болон бусад харилцагчид өөрчлөн байгуулагдсан тухайгаа бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд дараах зүйлийг тусгана:

11.2.1. өөрчлөн байгуулсан арга, хэлбэр;

11.2.2. өөрчлөн байгуулагдсан болон түүний үр дүнд шинээр үүссэн компани тус бүрийн оноосон нэр болон байршил;

11.2.3. өөрчлөн байгуулах тухай шийдвэр гарсан он, сар, өдөр;

11.2.4. хуваах болон тусгаарлах замаар өөрчлөн байгуулж байгаа тохиолдолд хуваах баланс.

11.3. Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, энэ хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана.

11.4. Шүүх компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана:



- 11.4.1. дампуурсан;
- 11.4.2. нэг ч гишүүн үлдээгүй;
- 11.4.3. хуульд заасан бусад үндэслэл.

11.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буугдаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

11.6. Татан буулгах комиссыг томилсноор тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь татан буугдаж байгаа компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд төлөөлөн оролцоно.

### **АРВАН ХОЁР. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ**

12.1. Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:

12.1.1. хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;

12.1.2. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

12.1.3. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

12.1.4. хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

12.2. Дор дурдсан этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтан болон хувьцааны хяналтын багц эзэмшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд гэж үзнэ:

12.2.1. тэдгээрийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн;

12.2.2. тэдгээрийн эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү;

12.2.3. тэдгээр нь өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшдэг компанитай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд уг гэрээнд оролцогч талууд.

12.3. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компани, түүний харилцаа болон охин компанид учирсан хохирлыг гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

12.4. Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх, хэлцэл хийх журам зөрчсөн бол үр дагаврыг арилгах асуудлыг Компанийн тухай хуулиар зохицуулна.

12.5. Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно:

12.5.1. хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;

12.5.2. компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

12.6. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

12.7. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ санал нэгтгэйгээр гаргана.

#### АРВАН ГУРАВ. АЖИЛЛАХ ХҮЧ

13.1. Хөдөлмөрийн гэрээ, нийгмийн даатгал, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж зэрэг компанийн ажилтнуудтай холбогдох бүхий л асуудал Монгол Улсын Хөдөлмөрийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэгдэнэ.

13.2. Компанийн ажилтнууд дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

13.2.1. ажилтан нь аливаа байгууллага, аж ахуйн нэгжийн ашиг сонирхлыг төлөөлөхгүй байх;

13.2.2. албан үүрэгтээ үнэнч шударга хандаж, компанийн үйл ажиллагаа тогтоосон горимд харш байдлаар өөртөө, гэр бүл, төрөл төрөгсөд, хувийн болон ажлын харьцаатай хүмүүст хуулиас гадуур давуу эрх олгохгүй байх;

13.2.3. харилцагчийн данс, зээл, төлбөр тооцоо, бизнесийн ажиллагаатай холбоотой албан материал, тоон үзүүлэлт, дотоод дүрэм, журам заавар, нөхцлүүдийг хууль тогтоомж, дотоод заавар журамд зааснаас бусад тохиолдолд бусдад танилцуулах, ашиглуулах, нууцыг алдагдуулах хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх.

#### АРВАН ДӨРӨВ.БУСАД ЗҮЙЛ

14.1. Санхүүгийн жил: Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна.

14.2. Компани нь эд хөрөнгөө даатгуулж болно.



14.3. Энэхүү дүрмийг Монгол хэлээр 4 (дөрвөн) хувь үйлдэн, компанийн тэмдэг дарж, бүртгэх байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргад тус бүр нэг хувийг хадгалуулна. Дүрмийн эх хувиудын хооронд зөрүүтэй зүйл гарвал ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, эсхүл бүртгэх байгууллагад хадгалагдаж буй хувийг эх хувь болгоно.

14.4. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг энэхүү дүрэмд заасны дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь бүртгэх байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчин зүйлээр байдаг.

ХУРЛЫН ДАРГА



Э.СОДГЭРЭЛ

ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Р.БОЛДБААТАР

-- 0000 --